

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/218/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал Ж.Бямбажав Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШИН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 630
танай _____-ны № _____-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ХОЁР
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Э.ЭНХТӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 53,935.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 52,588.4 сая төгрөгийн зардал гаргаж 1,347.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын хэмжээг 3,839.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж, 2024 оны 7 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, нийтийн тээврийн 16 чиглэлд 155 автобусаар үйлчилж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хүрээнд 7 бүлэг, 48 зорилт, 54 шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж, хэрэгжилтийг 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	104,281,438.90	22,139,474.01
1.1.2	Дансны авлага	2,856,165,281.08	3,986,170,855.78
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	2,414,475.22
1.1.4	Бусад авлага	131,797,968.66	84,630,881.02
1.1.6	Бараа материал	2,639,093,844.25	2,119,830,018.31
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,381,548,342.74	1,879,769,763.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,112,886,875.63	8,094,955,467.34
1.2.1	Үндсэн хөрөнгө	63,874,252,562.20	87,343,776,136.17
1.2.2	Биет бус хөрөнгө	3,892,774,880.00	4,400,081,680.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	67,767,027,442.20	91,743,857,816.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	75,879,914,317.83	99,838,813,283.51
2.1.1.1	Дансны өглөг	2,546,584,798.27	1,739,619,460.87
2.1.1.2	Цалингийн өглөг	-	1,418,902.29
2.1.1.3	Татварын өр	943,704,922.66	1,732,936,189.78
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,895,875,615.01	1,025,415,580.62
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,400,000.00	19,669,981.83
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,391,565,335.94	4,519,060,115.39
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	38,834,221,579.00	37,161,543,561.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	38,834,221,579.00	37,161,543,561.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	44,225,786,914.94	41,680,603,676.39
2.3.1	Өмч:	7,163,111,109.28	53,256,353,137.84
2.3.1.1	- төрийн	7,163,111,109.28	53,256,353,137.84
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,673,743,500.00	4,673,743,500.00
2.3.6	Эздийн өмчийн бусад хэсэг	20,936,275,257.56	-
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(1,119,002,463.95)	228,112,969.28
2.3.9	Эздийн өмчийн дүн	31,654,127,402.89	58,158,209,607.12
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	75,879,914,317.83	99,838,813,283.51

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Борлуулалтын орлого (цэвэр)	21,593,159,644.12	50,540,048,442.04
2.	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,106,437,792.74	46,052,388,790.15
3.	Нийт ашиг (алдагдал)	6,486,721,851.38	4,487,659,651.89
4.	Түрээсийн орлого	-	32,308,000.00
5.	Хүүний орлого	-	36,249.22
8.	Бусад орлого	-	3,363,240,008.60
10.	Ерөнхий ба удирдлагын зардал	7,605,724,315.33	6,386,453,011.59
18.	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,119,002,463.95)	1,496,790,898.12
19.	Орлогын татварын зардал	-	149,675,464.89
20.	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(1,119,002,463.95)	1,347,115,433.23
22.	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,119,002,463.95)	1,347,115,433.23
24.	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(1,119,002,463.95)	1,347,115,433.23

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,099,386,366.84	4,673,743,500.00	(1,119,002,463.95)	31,654,127,402.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,163,111,109.28	-	-	7,163,111,109.28
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,163,111,109.28	-	-	7,163,111,109.28
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	4,673,743,500.00	-	4,673,743,500.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	20,936,275,257.56	-	-	20,936,275,257.56
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,119,002,463.95)	(1,119,002,463.95)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,099,386,366.84	4,673,743,500.00	(1,119,002,463.95)	31,654,127,402.89
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,099,386,366.84	4,673,743,500.00	(1,119,002,463.95)	31,654,127,402.89
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,099,386,366.84	4,673,743,500.00	(1,119,002,463.95)	31,654,127,402.89
17	Өмчид гарсан өөрчлөлт	25,156,966,771.00	-	-	25,156,966,771.00
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,347,115,433.23	1,347,115,433.23
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	53,256,353,137.84	4,673,743,500.00	228,112,969.28	58,158,209,607.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн	14,872,884,553.64	44,123,690,227.24
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,919,681,214.37	42,948,328,921.61
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	118,325,163.00	206,707,053.63
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,650,944,815.40	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	183,933,360.87	968,654,252.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	16,802,695,295.72	43,974,168,361.35
1.2.1	Ажиллагчдад төлсөн	9,325,759,315.49	21,200,022,034.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,087,986,773.46	7,192,162,250.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,182,817,442.00	1,593,571,933.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	920,238,098.63	2,471,644,847.54
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,544,593,329.00	9,043,795,870.36
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	82,048,980.00	1,582,515,459.99
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	291,503,597.88	448,841,946.23
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,367,747,759.26	441,614,018.48
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,929,810,742.08)	149,521,865.89
2.1	Мөнгөн орлогын дүн	-	36,249.22
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	36,249.22
2.2	Мөнгөн зарлагын дүн	70,377,000.00	231,700,080.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,377,000.00	231,700,080.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(70,377,000.00)	(231,663,830.78)
4.	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,000,187,742.08)	(82,141,964.89)
5.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,104,469,180.98	104,281,438.90
6.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,281,438.90	22,139,474.01

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 он	2025 он		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			21,593,159.3	52,379,293.4	53,935,632.7	32,342,473.4	249.8	1,556,339.3	103.0
1	Шугамын үйлчилгээний орлого	м.төг	2,020,596.8	5,721,745.0	5,262,035.6	3,241,438.8	260.4	(459,709.4)	92.0
	Санхүүжилтын орлого	м.төг	17,293,816.9	43,074,277.6	39,853,120.7	22,559,303.8	230.4	(3,221,156.9)	92.5
	Нөхөн олговор - Оюутан	м.төг	366,157.8	-	2,269,055.2	1,902,897.4	619.7	2,269,055.2	-
	Нөхөн олговор - Өндөр настан	м.төг	1,184,249.4	2,895,699.6	2,702,849.6	1,518,600.2	228.2	(192,850.0)	93.3
	Нөхөн олговор - Цагдаа, цэрэг	м.төг	55,731.8	213,611.2	18,856.6	(36,875.2)	33.8	(194,754.6)	8.8
	Тусгай үйлчилгээ	м.төг	217,306.4	350,000.0	434,130.5	216,824.1	199.8	84,130.5	124.0
	Түрээсийн орлого	м.төг	3,580.0	18,960.0	32,308.0	28,728.0		13,348.0	
	Үйл ажил-ны бусад орлого	м.төг	446,770.2	100,000.0	3,363,240.3	2,916,470.1		3,263,240.3	
	Үйл ажил-ны бус бусад орлого	м.төг	4,950.0	5,000.0	36.3	(4,913.8)		(4,963.8)	
2	Нийт орлого	-	21,593,159.3	52,379,293.4	53,935,632.7	32,342,473.4	249.8	1,556,339.3	103.0
3	Нийт зардал	м.төг	22,712,161.7	54,872,010.7	52,438,841.8	29,726,680.1	230.9	(2,433,168.9)	95.6
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(1,119,002.4)	(2,492,717.3)	1,496,790.9	2,615,793.3	(133.8)	3,989,508.2	(60.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(1,119,002.4)	(2,492,717.3)	1,347,115.5	2,615,793.3	18.9	3,989,508.2	7.4
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	2,373,904.6	62,056.0	5,327,962.0	2,954,057.4	224.4	5,265,906.0	8,585.7
	а/ Орлогын татварт	м.төг	-	-	149,675.4	149,675.4	-	149,675.4	-
	в/ НДШ	м.төг	1,323,920.2	-	2,956,185.9	1,632,265.7	223.3	2,956,185.9	-
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	1,023,704.9	-	2,190,844.2	1,167,139.3	214.0	2,190,844.2	-
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	26,279.5	62,056.0	31,037.2	4,757.7	118.1	(31,018.8)	50.0
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	-	-	219.3	219.3	-	219.3	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	734.0	734.0	734.0	-	100.0	-	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	11,279,714,400.0	23,415,030.7	24,764,339.1	(11,254,950,060.9)	0.2	1,349,308.4	105.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,280,621.5	2,658.4	2,811.6	(1,277,810.0)	0.2	153.2	105.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.1	1.0	1.0	(0.1)	92.4	(0.1)	92.8
13	Нийт авлага	м.төг	2,987,963,249.0	-	4,073,216.2	(2,983,890,032.8)	0.1	4,073,216.2	-
14	Нийт өглөг	м.төг	44,225,786,914.0	-	41,680,603.6	(38,797,060,035.5)	0.1	41,680,603.6	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	38,834,221,579.0	-	37,161,543.5	(38,797,060,035.5)	0.1	37,161,543.5	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нийт 5,647,772.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлого үр дүнгийн тайланд 241.3 мянган төгрөгөөр бусад орлогыг дутуу тайлагнасан байна.	1	241.3			1	241.3	1	241.3				
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын гүйлгээг 1,022.4 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийж бүртгэсэн байна.	1	1022.4			1	1022.4	1	1022.4				
Шүүгээний элэгдэл, хорогдлыг байгуулаагүй байна.	1	280.0	1	280.0			1	280.0				
Бараа материалын дансанд 769.7 мянган төгрөгийн 11 клвт-н цахилгаан мотор орлого авч бүртгэсэн байна.	1	769.7			1	769.7	1	769.7				
Дээд газрын шийдвэргүйгээр 5,645,458.8 мянган төгрөгийн өртөг бүхий барилга байгууламжийг нийтийн эзэмшлийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.	1	5,645,458.8			1	5,645,458.8	1	5,645,458.8				
Дүн	5	5,647,772.2	1	280.0	4	5,647,492.2	5	5,647,772.2				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 218,107.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 7,452.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 58,455.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 152,199.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Харилцагч 19 аж ахуйн нэгжид хөрөнгө, материал бэлтгэх зориулалтаар 58,455.4 мянган төгрөгийн бэлэн мөнгө олгож данс бүртгэлд тусгасан байна.	1	58,455.4	-	-	1	58,455.4	-	-	-	-	-	-
Байгууллагын Голомт банкин дахь харилцах данснаас анхан шатны баримтын бүрдлийг хангахгүйгээр 105,809.1 мянган төгрөгийн 54 гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан байна.	1	105,809.1	-	-	-	-	1	105,809.1	-	-	-	-
Голомт банканд хугацаа хоцроосон зээлийн хүүгийн төлбөрт 7,452.0 мянган төгрөгийг төлсөн байна.	1	7,452.0	1	7,452.0	-	-	-	-	-	-	-	-
Байгууллага 32.308.0 мянган төгрөгийн түрээсийн орлогын гэрээ дүгнэж тооцоо хийгээгүй байна	1	32,308.0	-	-	-	-	1	32,308.0	-	-	-	-
Цалин хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварыг 3,250.0 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд илүү тайлагнасан байна.	1	3,250.0	-	-	-	-	1	3,250.0	-	-	-	-
Бичиг хэргэг, Хөдөлмөр хамгаалал, Хангамж, сэлбэг хэрэгслийн данснаас зарлагын гүйлгээ гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангахгүйгээр 10,599.5 мянган төгрөгийн 9 гүйлгээг хийж данс бүртгэлд тусгасан байна.	1	10,599.5	-	-	-	-	1	10,599.5	-	-	-	-
Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан,үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад 3 газрын хэмжээ нь газрын кадастрын нэгдсэн системийн бүртгэлээс нийт 5 м.кв-аар илүү бүртгэлтэй байна.	1	233.2	-	-	-	-	1	233.2	-	-	-	-
Дүн	7	218,107.2	1	7,452.0	1	58,455.4	5	152,199.8	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.